



НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗӨВЛӨЛИЙН ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛ

2025 оны 10 сарын 30 өдөр

Дугаар 18

Улаанбаатар хот

“БОДЛОГЫН СУДАЛГАА, ШИНЖИЛГЭЭНИЙ ТӨВ”-д

Нийслэлийн Засаг даргын зөвлөлийн 2025 оны 10 дугаар сарын 30-ны өдрийн 18 дугаар хуралдааны тэмдэглэлд:

“З.ХЭЛЭЛЦСЭН нь: “Нийслэлийн нутгийн захиргааны байгууллагуудын хүний нөөцийг хиймэл оюун (AI)-аар орлуулах мастер төлөвлөгөө”-ний төсөл

Бодлогын судалгаа, шинжилгээний төвийн захирал Р.Дагва танилцуулав.

ШИЙДВЭРЛЭСЭН нь:

1.Нийслэлийн нутгийн захиргааны байгууллагуудын хүний нөөцийг хиймэл оюун (AI)-аар орлуулах мастер төлөвлөгөө”-ний төсөлд тусгагдсан ажлыг байгууллагууд туршилтаар хэрэгжүүлэхэд нэгдсэн удирдлагаар хангаж, мастер төлөвлөгөөг тодорхой нэгж, ажлын байранд туршиж үр дүнд үндэслэн эргэж танилцуулж 2025 онд багтаан батлуулж ажиллахыг Нийслэлийн Засаг даргын Тамгын газар (Д.Амгалан)-т;

2. Мастер төлөвлөгөөнд тусгагдсан зорилт, үйл ажиллагааг 2025-2030 онд үе шаттайгаар хэрэгжүүлж, төрийн үйлчилгээний үр ашгийг нэмэгдүүлэх, зардлыг бууруулах, байгууллагын бүтээмжийг сайжруулах арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг нийслэлийн нутгийн захиргааны байгууллагын удирдлагуудад;

3. Их өгөгдөл, түүнийг нэгтгэн боловсруулах бодлого хөтөлбөрт ашиглах боломжийг бүрдүүлэх зорилгоор мэдээллийн менежментийн нэгж байгуулах эсэх мэргэжлийн байгууллагатай хамтран судалж, саналаа 2026 оны 1 дүгээр сард багтаан танилцуулахыг Нийслэлийн Засаг даргын Тамгын газар (Д.Амгалан)-т;

4.Хот, нийтийн аж ахуй, инженерийн дэд бүтцийн ашиглалт, үйлчилгээний чиглэлээр иргэдээс ирсэн гомдол, саналыг барагдуулах ажлыг AI рүү шилжүүлэхтэй холбоотойгоор гомдол, саналыг эрэмбэлэх, шилжүүлэх дарааллыг тогтоож, хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөөг холбогдох нэгжүүдтэй хамтран гаргаж 2026 оны 1 дүгээр улиралд багтаан танилцуулахыг Улаанбаатар хотын Захирагчийн ажлын алба (Г.Батзориг)-нд;

5.Нийслэлийн нутгийн захиргааны байгууллагуудын хүний нөөцийг хиймэл оюун (AI)-аар орлуулахад бэлтгэх Ажлын хэсгийг байгуулах захирамж гаргахыг Нийслэлийн Засаг даргын Тамгын газар (Д.Амгалан)-т;

1725270744

6. Нийслэлийн нутгийн захиргааны байгууллагуудад байгаа зарим сул орон тоон дээр туршилт хийх зорилгоор AI нэвтрүүлж ажиллахыг Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын Төрийн захиргааны удирдлагын газар (Ү.Ганболд)-т, програм хангамж худалдаж авах, хиймэл оюуныг туршиж үйл ажиллагаандаа нэвтрүүлж ажиллахыг Нийслэлийн Засаг даргын Тамгын газар (Д.Амгалан)-т үүрэг болгов.” гэжээ.

НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗАР

